



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/116

Шивээговь сум

Тамхи худалдан борлуулах тусгай  
зөвшөөрлийн хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол “Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Н.Цогзолмаагийн эзэмшлийн Нэртийн булаг хүнсний дэлгүүрийн тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлэхийг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхзаяа)-д үүрэг болгосугай.

3. Тамхи худалдан борлуулах үйл ажиллагааг “Тамхины хяналтын тухай” хуулийн 5, 6 дугаар зүйл, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийг тус тус мөрдөж ажиллахыг иргэн (Н.Цогзолмаа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнхзаяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ТАНЧИМЭГ

421220432